



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1995 оны 03 дугаар  
сарын 02-ны өдөр

№.13

Улаанбаатар  
хот

Хороо татан буулгах, шинээр  
байгуулах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс  
ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 16 дугаар тогтоол, Засгийн газрын 23 дугаар тогтоолын дагуу Гачуурт, Жаргалант, Туул дүүрэг буугдаж тосгон болсонтой холбогдуулан дээрх 3 дүүргийн 6 хороог татан буулгаж Баянзүрх дүүрэгт 20, Сонгинохайрхан дүүрэгт 21, Хан-Уул дүүрэгт 13 дугаар хороог тус тус шинээр байгуулсугай.

2. Гачуурт, Жаргалант, Туулд шинээр хороо байгуулсантай уялдуулан хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Хорооны Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгох хурлыг 1995 оны 3 дугаар сарын 10-ны дотор багтаан зохион байгуулахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ц.Болдсайхан/, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон Засаг дарга /Г.Цэрэнбаатар, Т.Дашням, Т.Билэгт/ нэрт даалгасугай.

3. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс болон тус дүүргийн 16 дугаар хорооны иргэдээс гаргасан саналыг үндэс-

лэн тус дүүргийн 16, 17 дугаар хорооны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороог шинээр байгуулсугай.

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮ-  
ЛЭГЧДИЙН ДАРГА




Ж.ЯЦАМСҮРЭН

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА



Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД




П.ГАНБААТАР

Л.ГАРАМЖИЛ

Л.ДАШНЯМ




Г.ӨЛЗИЙ



А.ЦАНЖИД

Б.ЦЭДЭВ



Ж.ЭРДЭНЭЧИМЭГ